



ЛАБОРАТОРИЙН ТЕНИКЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
2. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилд тухайн лабораториод 2-оос доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Тухайн лабораториод техникч нарт жилд 3-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 2-оос доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
2. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
3. Жилд мэргэжлийн 3-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд тухайн лабораториод 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Тухайн лабораториод техникч нарт жилд 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 3-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.